



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022, 2023 ОНЫ ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 83.4 ХУВЬТАЙ
БАЙНА

АУДИТЫН НЭР: АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ (2022, 2023 ОН)

АУДИТЫН КОД: АРА-2024/41-ШТА-НА

Архангай аймаг 2024 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Утас: 99339725 Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn
Аудитор В.Цогжаргал
Утас: 99158257 Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn
Аудитор Н.Дашмягмар
Утас: 99164665 Цахим хаяг: Dashmyagmarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. www.open.audit.mn

Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	➤ Товчилсон үгийн тайлбар ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор П.Цэцэгдулам Аудитор Н.Дашмягмар В.Цогжаргал 2024 оны 08 дугаар сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	БҮЛЭГ 1. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022, 2023 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ЗАРИМ ТАХ НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДААГҮЙ БАЙНА 1.1. Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний 25 ТАХ-дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна 1.2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан зарим төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцээгүй байна 1.3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд боловсруулах, төслийг олон талын оролцоог хангаж иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна БҮЛЭГ 2. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА 2.1 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 83.4 хувьтай байна 2.2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу баримт нотолгоонд үндэслэн бодитой үнэлээгүй байна Дүгнэлт Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Холбогдох байгууллагын санал Графикийн товьёг Хүснэгтийн товьёг	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЭЗХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт ТАХ-ний тоо	5
График 2	Төсөв хөрөнгө шаардлагатай ТАХ /хувиар/	10
График 3	ТАХ-ний гүйцэтгэл /тоогоор/	14
График 4	ТАХ-ний гүйцэтгэл /бодлогын ангиллаар/	14
График 5	ТАХ-ний зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан	14

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх ТАХ	5
Хүснэгт 2	Бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа	6
Хүснэгт 3	Монгол Улсын төсвийн тухай хуультай нийцсэн байдал	7
Хүснэгт 4	Санхүүжих дүн зөрүүтэй тусгагдсан ТАХ /сая төгрөг/	7
Хүснэгт 5	Шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээний тоо /давхардсанаар/	9
Хүснэгт 6	ТАХ-ний зураг төсвийн мэдээлэл	10
Хүснэгт 7	Төсөв хөрөнгө шаардлагатай ТАХ /тоогоор/	10
Хүснэгт 8	Төлөвлөгөө боловсруулсан, баталсан хугацааны мэдээлэл	12
Хүснэгт 9	ТАХ-г гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байдал	13
Хүснэгт 10	ТАХ-ний төлөвлөлт /сая.төгрөг/	13
Хүснэгт 11	2022, 2023 онд хэрэгжээгүй ТАХ-ний жагсаалт /сая.төгрөг/	15
Хүснэгт 12	Санхүүжилтийн гүйцэтгэл /сая.төгрөг/	16
Хүснэгт 13	Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/	17
Хүснэгт 14	ТАХ-ний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт	18

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй төсөл арга хэмжээний жагсаалт	23-24
Хавсралт 2	Төсвийн тухай хуульд санхүүжих дүн хасагдаж туссан төсөл арга хэмжээ /сая.төгрөг/	25
Хавсралт 3	Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нэмэгдэж туссан төсөл арга хэмжээ /сая.төгрөг/	26
Хавсралт 4	Шаардлагатай хөрөнгийн хэмжээг тусгаагүй ТАХ	27-28

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ:

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө нь хууль, журамд заасан шаардлага, тухайн жилийн төсвийн тухай хууль, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх
2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт нь үр нөлөөтэй, гүйцэтгэлийг бодитой үнэлсэн эсэх

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулсан, хэрэгжүүлсэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд, баталж, хэрэгжилтийг үнэлсэн аймгийн ИТХ болон холбогдох хэрэгжилтийг ханган ажилласан холбогдох байгууллагуудыг хамруулан 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт үнэлгээ, тайлагналын баримт материалыг шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардлагатай нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгаж, судалгаа дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль
- Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2021, 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль
- Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"
- Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"
- Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Архангай аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө"
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 08 дугаар тогтоолоор баталсан "Архангай аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө"
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Архангай аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"
- Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам"
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд
- Төсөл, арга хэмжээний батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ болон бусад шаардлагууд.

АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:


Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Цэцэгдулам, аудитор Н.Дашмягмар, В.Цогжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.05.20-2024.08.02-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022, 2023 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ЗАРИМ ТАХ НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДААГҮЙ БАЙНА

Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний 25 ТАХ дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.

1.1.1 Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 12 дугаар тогтоолоор 2022 оны жилийн төлөвлөгөөг 6 бүлэг, 16 зорилт, 175 ТАХ-тэй, ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 2023 оны жилийн төлөвлөгөөг 5 бүлэг, 16 зорилт, 166 ТАХ-тэй тус тус төлөвлөж баталсан байна.

График 1. Жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт ТАХ-ний тоо



Графикаас харахад 2022, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт ТАХ-ний 47-49 хувийг “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 1. “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх ТАХ

Бодлого	Зорилт	ТАХ-ний тоо	
		2022	2023
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	Эрүүл мэндийн үйлчилгээ	16	16
	Нийтийн биеийн тамир, спорт	4	1
	Боловсрол, шинжлэх ухаан	31	39
	Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл хүүхэд залуучууд	20	15
	Үндэсний өв соёл, соёл урлаг	12	10
Нийт дүн		83	81

Дээрх хүний хөгжлийн бодлогын хүрээнд төлөвлөсөн нийт ТАХ-ний 37-48 хувь нь

боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажил байна.

“Хөгжлийн бодлого” гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгаасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг¹ хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд үүнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого², “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”³ “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”⁴, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”⁵, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”⁶, “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”⁷ зэрэг урт, дунд, богино хугацааны баримт бичгүүд хамаарна.

Аймгийн 2022, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган баталсан арга хэмжээнүүд нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний бодлогын зорилго⁸, бодлогын зорилт⁹, арга хэмжээтэй нийцсэн эсэхийг харьцуулан шинжлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа

Он	Бүх баримт бичгүүдтэй уялдсан	Аль нэг бодлогын баримт бичигтэй уялдсан	Бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй	Нийт
2022	78	97	0	175
2023	61	80	25	166

Эх сурвалж: Аудиторын тооцоолол /Дэлгэрэнгүйг хавсралт-1-ээс харна уу/

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд Архангай аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж баталжээ.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 4.1.14-д **"Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө"** гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв,

¹ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

² 4.1.4. "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичгийг

³ 4.1.6. "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилсан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг

⁴ 4.1.7. "Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг

⁵ 4.1.8. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг

⁶ 4.1.10. "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг

⁷ 4.1.13. "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг

⁸ 4.1.16. "Бодлогын зорилго" гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг

⁹ 4.1.17. "Бодлогын зорилт" гэж бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтийг

санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг", 6.10-д "Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна" 6.10.1-д "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг Үндэсний хөгжлийн газраас /хуучин нэрээр/ хянаж 2021.11.11-ний өдрийн 01/668 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг ЭЗХЯ-аас хянаж 2022.09.30-ны өдрийн 01/1107 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг бүрэн хэрэгжүүлээгүй, төлөвлөгөөг баталжээ.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9.11.1. ... Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан эсэх талаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсхүл буцаах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан батлах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлээ.

1.1.2 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан нийт 341 ТАХ-ээс "Улсын төсөв"-ийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан 116 ТАХ байна. Эдгээр ТАХ-г Монгол Улсын 2022, 2023 оны Төсвийн тухай хуультай нийцүүлэн авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Монгол Улсын төсвийн тухай хуультай нийцсэн байдал

Он	Нийт ТАХ-ны тоо	Улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжих ТАХ-ний тоо	Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд туссан	Монгол Улсын 2022 2023 оны төсвийн тухай хуульд тусаагүй
2022	175	70	35	35
2023	166	46	38	8
Нийт дүн	341	116	73	43

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-г Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуультай нийцүүлэн үзэхэд 20 ТАХ-ний санхүүжих дүн зөрүүтэй байлаа. Үүнд:

Хүснэгт 4: Санхүүжих дүн зөрүүтэй тусгагдсан ТАХ /сая төгрөг/

Үзүүлэлт	Он	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн
Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь хасагдаж туссан	2022	11	33,824.7
	2023	3	372.3
Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь нэмэгдэж туссан	2023	6	2,929.6
Нийт дүн		20	37,126.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол /Дэлгэрэнгүйг хавсралт-2-оос харна уу/

Хүснэгтээс харахад Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нийт 11 төсөл арга хэмжээний санхүүжих дүн 33,824.7 сая төгрөгөөр хасагдаж, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 3 төсөл арга хэмжээний санхүүжих дүн 372.3 сая төгрөгөөр хасагдаж, 6 төсөл арга хэмжээний санхүүжих дүн 2,929.6 сая төгрөгөөр нэмэгдэж тусжээ.

1.2 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан зарим төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцээгүй байна

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад дараах шаардлагыг хангасан байхаар тусгасан. Үүнд:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан 17 зарчмыг баримталж боловсруулна;
2. Төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана;
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.

1.2.1 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулж, баталсан эсэхийг нийцүүлэн шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Зөрчлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээний тоо /давхардсанаар/

№	Зөрчил	Арга хэмжээний тоо /давхардсан тоогоор/	
		2022	2023
1	Шалгуур үзүүлэлт ¹⁰ ийг тодорхойлоогүй	19	2
2	Суурь түвшнийг ¹¹ тодорхойлоогүй	19	1
3	Зорилтот түвшнийг ¹² тодорхойлоогүй	8	1
4	Хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүнг тодорхойлоогүй	175	166

¹⁰ 4.1.22."шалгуур үзүүлэлт" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг;

¹¹ 4.1.20."суурь түвшин" гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгыг

¹² 4.1.23."зорилтот түвшин" гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгыг;

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.2.2 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдийн санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тодорхойлон тусгасан боловч эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэлийг тодорхойлоогүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл ... тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаас аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн тодорхойлж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэлийг тусган боловсруулах албан шаардлагыг аймгийн засаг дарга, ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлээ.

1.2.3 Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-ний 53.2 хувь, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-ний 42.8 хувь нь ТЭЗҮ болон зураг төсөв шаардлагатай ТАХ байна. Эдгээр ТАХ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалттай нийцсэн байна.


Хүснэгт 6. ТАХ-ний зураг төсвийн мэдээлэл

Он	Нийт ТАХ	Үүнээс:	
		Зураг төсөв шаардлагатай	Зураг төсөв шаардлагагүй
2022 он	175	93	82
2023 он	166	71	95
Нийт	341	164	177

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.2.4 Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 175 арга хэмжээнээс төсөв хөрөнгө шаардлагагүй 46, шаардлагатай 129, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 166 арга хэмжээнээс төсөв хөрөнгө шаардлагагүй 25, шаардлагатай 141 ТАХ байна. Үүнд:

График 2. Төсөв хөрөнгө шаардлагатай ТАХ /хувиар/



Хүснэгт 7. Төсөв хөрөнгө шаардлагатай ТАХ /тоогоор/

Он	Төсөв хөрөнгө шаардлагатай нийт ТАХ-ний тоо	Үүнээс:	
		Хөрөнгийн хэмжээг тусгасан ТАХ-ний тоо	Хөрөнгийн хэмжээг тусгаагүй ТАХ-ний тоо
2022 он	129	113	16
2023 он	141	126	15
Нийт	270	239	31

Эх сурвалж: Аудиторын тооцоолол /Дэлгэрэнгүйг хавсралт-3-аас харна уу/

Үндэсний хөгжлийн газар, Эдийн засаг хөгжлийн яамнаас 2022,2023 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хянаж хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр тодорхойгүй ТАХ-г хуулийн шаардлагыг хангасны дараа төлөвлөгөөнд тусгах шаардлагатай талаар албан бичгээр санал, зөвлөмж ирүүлжээ.

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тусгаагүй 31 ТАХ-г дээрх санал, зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр баталсан нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-д “Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон ... техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаас зөрчлийг арилгаж хуулийн шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж батлуулах, хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.2.5 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг эрэмбэлээгүй, үүнийг тодруулахад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулах, мөн улс, аймгийн урт дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх зарчмын хүрээнд боловсруулдаг бөгөөд эрэмбэлэх шаардлагагүйгээр боловсруулдаг” гэсэн тайлбарыг аймгийн ЗДТГ-ын 2024.07.09-ний 03/1054 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-д "... тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаас аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах төсөл арга хэмжээг эрэмбэлж, урьдчилсан жагсаалтын бэлтгэж олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

1.3 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд боловсруулах, төслийг олон талын оролцоог хангаж иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна

1.3.1 Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд 2 агентлагаас нийт 15 санал авч 8 саналыг тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд, 2023 оны төлөвлөгөөнд эдийн засаг хөгжлийн яам, 11 сумаас давхардсан тоогоор 123 санал авч 30 саналыг тусгасан байна. Өөрөөр хэлбэл аймгийн хөгжлийн тухайн жилийн төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн саналыг хүртээмжтэй хэлбэрээр авч тэдгээрийн саналд үндэслэн боловсруулаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.12-д "төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж ... "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг, 5.2.13-д "бүх талын оролцоог хангасан байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.3.2 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний төслийг иргэд олон нийтээр хэлэлцүүлээгүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.3.3 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг томилсон, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны байгууллагаас санал авсан, төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар баталсан хугацааны талаарх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Төлөвлөгөө боловсруулсан, баталсан хугацааны мэдээлэл

Он	Ажлын хэсэг байгуулсан захирамжийн огноо, дугаар	ХБТХТЗБ-аас санал ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Төлөвлөгөөг баталсан аймгийн ИТХ-ын тогтоолын огноо, дугаар
2022	2021.10.11-ний А/641	2021.11.11-ний 01/668	2021.12.02-ны 12
2023	2022.09.06-ны А/642	2022.09.30-ны 01/1107	2022.09.30-ны 08

Эх сурвалж: Аймгийн ХБТХОХ-ийн мэдээлэл

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөг боловсруулах нарийвчилсан заавар, аргачлал байхгүйгээс хуульд заасан цаглаварт хугацаанаас хоцроож боловсруулсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна”, 18.6-д “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаас аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд олон нийтийн оролцоог хангаж тэдний саналд үндэслэн боловсруулах албан шаардлага, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд боловсруулж, батлуулах зөвлөмжийг аймгийн засаг даргад хүргүүлээ.

БҮЛЭГ 2. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА

2.1 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 83.4 хувьтай байна

2.1.1 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн болон хамтран хариуцагч байгууллагуудыг тодорхойлон баталсан. Үүний дагуу нийт батлагдсан ТАХ-ний 82.1 хувь буюу 280 ТАХ-г үндсэн хариуцагч байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж, 17.9 хувь буюу 61 ТАХ-г заавал тусгах шаардлагагүй тул тусгаагүй байна.

Хүснэгт 9. ТАХ-г гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байдал

Он	Нийт ТАХ	Байгууллагын төлөвлөгөөнд тусгасан	Байгууллагын төлөвлөгөөнд тусгаагүй
2022	175	142	33
2023	166	138	28
Нийт	341	280	61

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.1.2 Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд 175 ТАХ-г 165,791.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсний 40.0 хувь нь улсын төсвийн, 5.7 хувь нь улс, орон нутгийн төсвийн, 23.4 хувь нь орон нутгийн төсвийн, 0.6 хувь нь сангийн, 4.6 хувь нь төсөл хөтөлбөрийн, 25.7 хувь нь эх үүсвэргүй баталсан байна.

2023 оны жилийн төлөвлөгөөнд 166 ТАХ-г 196,810.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсний 27.7 хувь нь улсын төсвийн, 14.5 хувь нь улс, орон нутгийн төсвийн, 43.4 хувь нь орон нутгийн төсвийн, 4.2 хувь нь сангийн, 4.2 хувь нь төсөл хөтөлбөрийн, 6.0 хувь нь эх үүсвэргүй баталсан байна. Үүнийг санхүүжилтийн эх

үүсвэрээр харуулбал:


Хүснэгт 10. ТАХ-ний төлөвлөлт /сая.төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	ТАХ-ний тоо		Санхүүжилтийн дүн	
		2022 он	2023 он	2022 он	2023 он
1	Улсын төсөв	70	46	160,200.1	177,617.4
2	Улс, орон нутгийн төсөв	10	24	1,933.6	3,556.1
3	Орон нутгийн төсөв	41	72	3,521.2	6,109.9
4	Сан	1	7	1,000.0	3,090.0
5	Төсөл хөтөлбөр	8	7	2,800.0	6,437.0
6	Эх үүсвэргүй баталсан	45	10	0.0	0.0
Нийт дүн		175	166	169,454.9	196,810.4

Эх сурвалж: Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөө


Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ-ний гүйцэтгэл дараах байдалтай байна.

График 3. ТАХ-ний гүйцэтгэл /тоогоор/



Дээрх үзүүлэлтээс харахад 2022, 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 341 ТАХ-ний 56.9 хувь буюу 194 ТАХ нь зорилтот түвшинд хүрсэн, 43.1 хувь буюу 147 ТАХ нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Үүнийг бодлогын ангиллаар харуулбал:


График 4. ТАХ-ний гүйцэтгэл /бодлогын ангиллаар/



Зорилтот түвшиндээ хүрээгүй 147 ТАХ-ний дийлэнх хувь буюу 55.1 хувь нь “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд, 19.1 хувь нь “Эдийн засаг хөгжлийн бодлого”-ын

хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ байна. Эдгээр нь дараах шалтгааны улмаас зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Үүнд:

График 5. ТАХ-ний зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан



Дээрх байдлаас харахад ТАХ бүрэн хэрэгжээгүй, зорилтот түвшиндээ хүрээгүй гол шалтгаан нь хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын зохион байгуулалт, хамтын ажиллагаа дутмаг, гүйцэтгэгч байгууллагуудын гэрээний хэрэгжилт хангалтгүй, санхүүжилт бүрэн шийдэгдээгүйтэй холбоотой байна.

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан дараах 14 ТАХ нь хэрэгжээгүй байна. Үүнд:

Хүснэгт 11 2022, 2023 онд хэрэгжээгүй ТАХ-ний жагсаалт /сая.төгрөг/

№	ТАХ-ны нэр	Санхүүжилт ийн дүн	Санхүүжилтийн эх үүсвэр	Хэрэгжээгүй шалтгаан
2022 он				
1	Эрдэнэбулган сумын 2 дугаар сургуулийг Дизайн технологийн эрэгтэй кабинет техник, тоног төхөөрөмжөөр хангах	25.0	Улсын төсөв	Санхүүжилт шийдэгдээгүй
2	Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн номын санг нэгдсэн сүлжээнд холбож, цахим номын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх	7.0	Орон нутгийн төсөв	
3	Хөгжимт драмын театрын барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлэх	2,475.9	Улсын төсөв	Гүйцэтгэгч байгууллагын гэрээний хэрэгжилт хангалтгүй
4	"Төв Монголын байгаль- түүх, соёлын цогцолбор музей"-н барилга угсралтын ажлыг эхлүүлэх	750.0	Улсын төсөв	
5	Өлзийт сум дахь Өөлд Бэйсийн хийдийг сэргээн засварлах	50.0	Улсын төсөв	Санхүүжилт шийдэгдээгүй
6	Өлзийт сум дахь Алтан зуу хийдийг сэргээн засварлах	500.0	Улсын төсөв	
7	Зорчигч болон ачаа тээврийн хяналт, бүртгэл, байршлын	100.0	Орон нутгийн төсөв	Зохин байгуулалт хамтын

	хяналтын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх			ажиллагаатай холбоотой
8	Цэнгэлдэх хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх	1,900.0	Улсын төсөв	Санхүүжилт шийдэгдээгүй
9	Эрдэнэбулган сумын Хоршоолол багт 160 суудалтай хичээлийн байр барих	1,190.0	Улсын төсөв	Гүйцэтгэгч байгууллагын гэрээний хэрэгжилт хангалтгүй
2023 он				
1	Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын барилгыг засварлах	40.0	Орон нутгийн төсөв	Санхүүжилт шийдэгдээгүй
2	Төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	-	-	Зохион байгуулалт хамтын ажиллагаатай холбоотой
3	Цахир сумын төв доторх хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлэх	500.0	Орон нутгийн төсөв, бусад	Гүйцэтгэгч байгууллагын гэрээний хэрэгжилт хангалтгүй
4	Тариат сумын Цагаан нуур баг Тэрхийн голд гүүр барих	150.0	Орон нутгийн төсөв	Худалдан авах ажиллагаатай холбоотой
5	Хангай сумын Баян-Улаан багт гүүр барих	200.0	Орон нутгийн төсөв	

2.2 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу баримт нотолгоонд үндэслэн бодитой үнэлээгүй байна

2.2.1 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр ХБТХОХ-ээс тайлагнаж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн дүгнүүлж, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд гүйцэтгэл 127,143.8 сая төгрөг буюу 75 хувь бол, 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл 182,046.4 сая төгрөг буюу 92.5 хувьтай байна. Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 12. Санхүүжилтийн гүйцэтгэл /сая.төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Санхүүжилтийн гүйцэтгэл			
		2022 он	Хувь	2023 он	Хувь
1	Улсын төсөв	121,358.0	75.7	169,293.7	95.3
2	Улс, орон нутгийн төсөв	1,825.2	94.4	3,252.7	91.5
3	Орон нутгийн төсөв	3,410.6	96.8	4,846.1	79.3
4	Сан	550.0	55.0	3,016.9	97.6
5	Төсөл хөтөлбөр	0.0	0.0	1,637.0	25.4
Нийт дүн		127,143.8	75.0	182,046.4	92.5

Эх сурвалж: Аймгийн ХБТХОХ-ээс ирүүлсэн гүйцэтгэл

2.2.2 Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний

биелэлтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу жил бүр үнэлж ЗГХЭГ-т үнэлгээг хүргүүлсэн байна. Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг ХШҮХ болон аудитаар үнэлсэн байдлыг харьцуулан харуулбал:

Хүснэгт 13. Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/

№	Тодорхойлсон бодлого	ТАХ-ны тоо		ХШҮХ-ийн үнэлгээ		Аудитын үнэлгээ	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм ЭЗ-ийн хүндрэлийг даван туулах бодлого	6	-	96.7	-	80.0	-
2	Хүний хөгжлийн бодлого	83	81	76.0	86.6	73.2	84.5
3	Эдийн засгийн хөгжлийн бодлого	38	30	84.2	89.6	83.6	89.6
4	Засаглалын бодлого	23	29	85.6	97.9	85.6	92.9
5	Ногоон хөгжлийн бодлого	10	8	93.0	92.5	92.0	92.5
6	Бүс орон нутаг хөдөөгийн хөгжил	15	18	70.6	84.0	70.4	84.0
Нийт /дундаж/		175	166	84.5	90.1	78.2	88.7

Эх сурвалж: Үнэлгээ өгсөн байгууллагуудын үнэлгээ

Дээрх үнэлгээний хүснэгтээс харахад ХШҮХ-ийн үнэлгээ аудитын үнэлгээнээс зөрүүтэй, буурч байгаа нь төлөвлөгөөний биелэлтийг баримт нотолгоонд үндэслээгүй зөвхөн хариуцагч байгууллагаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд үндэслэн үнэлдэгтэй холбоотой байна. Тухайлбал:

Дээрх үнэлгээний хүснэгтээс харахад ХШҮХ нь “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлээгүй зөвхөн хариуцагч байгууллагаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд үнэлгээ өгч байна. Зарим ТАХ-г бодитой, бүрэн хэмжээнд үнэлээгүй байна. Тухайлбал:

- “Мобайл технологийг сумын эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх” ТАХ-ний хүрэх түвшин 2 эрүүл мэндийн төвд нэвтрүүлэхээр тодорхойлсон боловч төсөв хөрөнгө шийдэгдээгүйгээс зөвхөн Цэнхэр сумын эрүүл мэндийн төвд хэрэгжсэн байхад 100 хувиар үнэлсэн,
- “Суралцагчдын сургалтын ахиц дэвшлийн үнэлгээг хийж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах” ТАХ нь статистик мэдээ, хэрэгжилтийн тайлангаар зорилтод түвшиндээ хүрээгүй байхад 100 хувиар үнэлсэн,
- “Эрдэнэбулган сумын “Ирээдүй” сургууль- цэцэрлэгийн цогцолборын барилгыг засварлах”, “Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн спорт заалыг засварлах” ТАХ-ний санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан байхад үнэлгээг 70-100 хувиар үнэлсэн байна

Энэ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.2.3 "Хяналт шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, **баримт нотолгоонд** үндэслэн гаргах", 5.2.4 "Тайлан дахь хүрсэн түвшний талаарх **мэдээллийн үнэн,**

зөв эсэхийг нягтлан шалгах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу баримт нотолгоонд үндэслэн үнэлэх албан шаардлагыг аймгийн засаг дарга, аймгийн ХШҮХ-т хүргүүлээ.

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

- **2022 оны хувьд:** Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ээс 81 нь “Үр дүнтэй”, 55 нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 25 нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 14 нь “Үр дүнгүй” байна.
- **2023 оны хувьд:** Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ээс 113 нь “Үр дүнтэй”, 32 нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 13 нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 8 нь “Үр дүнгүй” байна.

Хүснэгт 14. ТАХ-ний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт

Бодлогын нэр	ТАХ-ний тоо		Үр дүнгийн үзүүлэлт								Аудитын үнэлгээ (хувиар)	
			Үр дүнтэй (100)		Тодорхой үр дүнд хүрсэн (99-70)		Эрчимжүүлэх шаардлагатай (69-30)		Үр дүнгүй (29-0)			
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм ЭЗ-ийн хүндрэлийг даван туулах бодлого	6		3		2		1				80	
Хүний хөгжлийн бодлого	83	81	32	51	30	20	12	6	9	4	73.2	84.5
Эдийн засгийн хөгжлийн бодлого	38	30	19	21	11	7	7	2	1	0	83.6	89.6
Засаглалын бодлого	23	29	15	26	4	1	3	1	1	1	85.6	92.9
Ногоон хөгжлийн бодлого	10	8	9	6		1		1	1	0	92	92.5
Бүс орон нутаг хөдөөгийн хөгжил	15	18	3	9	8	3	2	3	2	3	70.4	84.0
Нийт дүн	175	166	81	113	55	32	25	13	14	8	78.2	88.7

2.2.3 Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний холбогдох мэдээллийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан www.unelgee.gov.mn сайтад байршуулдаг бөгөөд иргэд хандах эрхгүй, эрх бүхий албан тушаалтан хандах эрхтэй байгаагаас харахад хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг иргэд олон нийтэд түгээх, мэдээлэх ажил хангалтгүй байна гэж үзэхээр байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.”Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний холбогдох мэдээллийг иргэд олон нийтэд мэдээлж ажиллах зөвлөмжийг аймгийн засаг дарга, аймгийн ХБТХОТ-т хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний 25 ТАХ-дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна
2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан зарим төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагад нийцээгүй байна
3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд боловсруулах, төслийг олон талын оролцоог хангаж иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна
4. Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 83.4 хувьтай байна.
5. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу баримт нотолгоонд үндэслэн бодитой үнэлээгүй байна.

Аудитын дүн: Аудитаар илэрсэн 10 зөрчилд 6 албан шаардлага, 3 зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан батлахад анхаарч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна”, 18.6-д “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасны дагуу хуулийн хугацаанд боловсруулж, батлуулахад арга хэмжээ авч ажиллах
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.”Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг... нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 1-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/29

Эрдэнэбулган сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитын тайланд тусгагдсан албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (П.Цэцэгдулам)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

D:\2024\Tyshaan.doc
650210092

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ**Хавсралт-1**

Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй төсөл арга хэмжээний жагсаалт

№	Арга хэмжээний дугаар	Арга хэмжээ	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Аймгийн 3Д-ийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө
1	1.1.15	Нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
2	1.1.16	Нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн орон сууцын газрын асуудлыг шийдвэрлэх	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
3	1.3.22	Эрдэнэбулган сумын “Ирээдүй” сургууль-цэцэрлэгийн цогцолборын барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
4	1.3.23	Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
5	1.3.25	Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
6	1.3.26	Хотонт сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
7	1.3.28	Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
8	1.3.29	Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн спорт заалыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
9	1.3.30	Эрдэнэбулган сумын Хоршоолол багийн ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны халаалтын шугамыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
10	1.3.31	Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
11	1.3.32	Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн кабинетийг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
12	1.3.34	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн бохир усны шугам сүлжээний засвар, шинэчилэл	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө

13	1.3.35	Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн засварлах 9-р барилгыг	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
14	1.3.36	Жаргалант сумын сургуулийн хичээлийн байр, спорт заалыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
15	1.5.4	Хайрхан сумын соёлын төвийг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
16	1.5.5	Ихтамир сумын соёлын төв, музейн барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
17	1.5.6	Төвшрүүлэх сумын соёлын төвийг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
18	1.5.7	Батцэнгэл сумын соёлын төвийг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
19	1.5.8	Музейн барилгыг засварлах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
20	2.4.4	Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй барилга байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
21	3.1.10	Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
22	3.4.1	МУ-ын өрлөг Жанжин маршал Г.Дэмид жанжны хөшөөг засварлах, суурийг шинэчлэх	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
23	3.4.2	Аймгийн түүхийн музейд аймгаас төрсөн генералуудын хүндэтгэлийн байрыг шинэчлэн байгуулах	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
24	5.1.17	Тариат сумын Цагаан нуур баг Тэрхийн голд гүүр барих	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
25	5.1.18	Хангай сумын Баян-Улаан багт гүүр барих	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгагдаагүй

Хавсралт-2

Төсвийн тухай хуульд санхүүжих дүн хасагдаж туссан төсөл арга хэмжээ /сая.төгрөг/

№	ТАХ-ний нэр	Санхүүжилтийн хэмжээ	Төсвийн тухай хуульд туссан тухайн жилд санхүүжих дүн	АХЖТ Төсвийн тухай хуульд туссан санхүүжилтийн зөрүү
2022 оны хувьд:				
1	Аймгийн төвд 300 ортой нэгдсэн эмнэлгийн барилга барих	10,000.0	6,200.0	(3,800.0)
2	Эрдэнэбулган сумын Хоршоолол багт 160 суудалтай хичээлийн байр барих	1,190.0	238.0	(952.0)
3	Эрдэнэбулган сумын 4 дүгээр сургуулийн хичээлийн байр, спорт заалны барилга барих	1,000.0	200.0	(800.0)
4	Хотонт суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих	1,000.0	600.0	(400.0)
5	Жаргалант сумын цэцэрлэгийн 50 ортой өргөтгөлийн барилгыг барих	600.0	120.0	(480.0)
6	Ихтамир сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг барих	700.0	140.0	(560.0)
7	Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлыг эхлүүлэх	7,000.0	840.0	(6,160.0)
8	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэх	12,000.0	6,109.7	(5,890.3)
9	Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажлыг үргэлжлүүлэх	2,700.0	1,500.0	(1,200.0)
10	Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлэх	13,980.0	1,677.6	(12,302.4)
11	Тариат, Хангай сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлыг эхлүүлэх	1,600.0	320.0	(1,280.0)
Нийт		51,770.0	17,945.3	(33,824.7)
2023 оны хувьд:				
1	Батцэнгэл суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих	1,882.2	1,878.3	(3.9)
2	“Малын үүлдэр угсааг сайжруулах төсөл”-ийг үргэлжүүлэх	320.0	271.0	(49.0)

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө

3	Цагдаагийн газрын барилгын ажлыг үргэлжлүүлэх	4,410.0	4,090.6	(319.4)
Нийт		6,612.2	6,239.9	(372.3)

Хавсралт-3

Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нэмэгдэж туссан төсөл арга хэмжээ /сая.төгрөг/

№	ТАХ-ний нэр	Санхүүжилтийн хэмжээ	2023 оны Төсвийн тухай хуульд туссан тухайн жилд санхүүжих дүн	АХЖТ Төсвийн тухай хуульд туссан санхүүжилтийн зөрүү
1	Өндөр-Улаан сумын Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто замын ажлыг үе шаттай эхлүүлэх	15,170.0	15,170.6	0.6
2	Хангай сумын төв доторх хатуу хучилттай авто замын ажлыг үе шаттай үргэлжлүүлэх	2,193.2	2,336.1	142.9
3	Чулуут сумын сургуулийн 320 суудалтай хичээлийн байрны өргөтгөл, урлаг, спортын заалны барилгыг ашиглалтад оруулах	493.0	493.9	0.9
4	Хотонт суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих	1,882.2	2,275.3	393.1
5	Жаргалант сумын цэцэрлэгийн 50 ортой өргөтгөлийн барилгыг барих	893.5	2,748.4	1,854.9
6	Ихтамир сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг барих	822.7	1,359.9	537.2
Нийт		21,454.6	24,384.2	2,929.6

Шаардлагатай хөрөнгийн хэмжээг тусгаагүй TAX /2022 он/

№	Зорилт	Арга хэмжээний дугаар	TAX
1	Эрүүл мэндийн үйлчилгээ	2.1.5.	Өлзийт, Хотонт, Тариат сумдад яаралтай тусламжийн цэг байгуулах
2		2.1.6.	Алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ийг А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх
3		2.1.7.	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх
4		2.1.9.	“Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх
5		2.1.11.	Мобайл технологийг Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх
6		2.1.12.	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
7	Боловсрол, шинжлэх ухаан	2.3.8.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хөгжлийг дэмжсэн арга хэмжээ хэрэгжүүлэх
8		2.3.10.	Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах
9	амар тайван, аюулгүй байдал	4.3.2.	Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх
10		4.3.5.	Цэцэрлэг хотын гол замын уулзваруудын гэрлэн дохиог нэмэгдүүлэх, засварлах
11		4.3.6.	Зам тээврийн осол, хэрэг давтамжтайгаар гардаг газруудад урьдчилан сэргийлэх самбар байршуулах
12		4.3.7.	Ус цаг уурын хяналт- шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник технологийн шинэчлэл хийх
13	Бүс орон нутаг, хөдөөгийн хөгжил, дэд бүтэц	6.1.2.	Цэцэрлэг хотод Дулааны станцыг барих ажлыг эхлүүлэх
14		6.1.6.	Иргэдийн орлогод нийцсэн орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих төслийг бодлогоор дэмжин сумдад “Тохилог орон сууц” арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх
15	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ	3.2.8.	Малчдын өвөлжөө, хаваржаанд тэжээлийн ургамал тариалахад дэмжлэг үзүүлэх
16	Барилга, хот байгуулалт,	3.4.2.	Цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, орон сууцнуудын гадна фасад, гэрэлтүүлэг, зам талбайг тохижуулж хотын үзэмжийг сайжруулах өнгө

Шаардлагатай хөрөнгийн хэмжээг тусгаагүй TAX /2023 он/

№	Зорилт	Арга хэмжээний дугаар	TAX
1	Эрүүл мэндийн үйлчилгээ	1.1.1	Хүн амыг нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэгт хамруулах
2		1.1.13	Мобайл технологийг сумын эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх
3	Боловсрол шинжлэх ухаан	1.3.4	“Хүүхэд хөгжил-Архангай” арга хэмжээг хэрэгжүүлэх
4		1.3.38	Мал хээлтүүлэгийн ажлыг биотехнологийн дэвшилтэд арга ашиглан зохион байгуулах

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө

5	Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, гэр бүл хүүхэд залуучууд	1.4.3	Гэр бүлийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангийн үр дүнг сайжруулах
6		1.4.13	Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд цахимаар чирэгдэлгүй хүргэх
7	Аялал жуулчлал	2.3.3	Нутгийн иргэд, нүүдлийн соёлд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Нүүдэлчдийн соёл”-ын цогц арга хэмжээг зохион байгуулах
8		2.3.4	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилчдыг “Гурван тамир политехник коллеж”-д мэргэшүүлэх зочлох үйлчилгээний сургалтад хамруулах
9	Барилга, хот байгуулалт	2.4.4	Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй барилга байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах
10	Цахим монгол-Төрийн шуурхай үйлчилгээ	3.1.3	“Цахим архив албан хэрэг хөтлөлт” арга хэмжээг хэрэгжүүлэх
11		3.1.4	Ёс зүйн болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох
12		3.1.8	Тариат суманд байгуулагдах Эрэн хайх, аврах бүлгийн багаж хэрэгсэл, хангалтыг нэмэгдүүлнэ
13		3.1.10	Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулах
14	Амар тайван, аюулгүй нийгэм	3.3.6	Зам тээврийн осол давтамжтайгаар гардаг газруудад урьдчилан сэргийлэх самбар, нойр сэргээгч байршуулах
15	Бүс орон нутаг, хөдөөгийн хөгжил, дэд бүтэц	5.1.2	Цэцэрлэг хотод Дулааны станцыг барих ажлыг эхлүүлэх



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 415/АДЗЖО462

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймгийн 2022, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг аймгийн Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс үнэлэхдээ баримт нотолгоонд үндэслээгүй зөвхөн хариуцагч байгууллагаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд үндэслэн үнэлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 5.2.3-т "Хяналт шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах", 5.2.4-т "Тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар⁶-т ирүүлэх

⁶ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019

650261232

- хэлэлцүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар⁵-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга Б.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Т.БАЙГАЛМАА
В.ЦОГЖАРГАЛ

⁵ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 414/А0370 462

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн саналыг хүртээмжтэй хэлбэрээр авч тэдгээрийн саналд үндэслэн боловсруулаагүй, эцэслэсэн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлээгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.12-д "төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж ... "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг, 5.2.13-д "бүх талын оролцоог хангасан байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг", 11 дүгээр зүйлийн 11.3-т "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд олон нийтийн оролцоог хангаж тэдний саналд үндэслэн боловсруулж, эцэслэсэн төслийг иргэд, олон нийтээр

650261228

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга Б.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Т.БАЙГАЛМАА
В.ЦОГЖАРГАЛ



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 413/10370462

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 21 төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, 20 төсөл арга хэмжээний суурь түвшин, 9 төсөл арга хэмжээний зорилтот түвшинг тодорхойлоогүй. Батлагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэлийг тусгаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл ... тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан шаардлагын дагуу боловсруулах арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар²-т ирүүлэх

² Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019

650261219



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 412/10370462

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг эрэмбэлээгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 "Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна", 6.10.2 "санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95-р дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгах төсөл арга хэмжээг эрэмбэлж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар⁴-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга Б.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

В.ЦОГЖАРГАЛ

⁴ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019


650261225

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга Б.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

В.ЦОГЖАРГАЛ



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 411/00370462

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд шаардлагатай хөрөнгийн хэмжээг тусгаагүй, хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй 31 төсөл арга хэмжээг баталсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 "Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна", 6.10.2 "санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тусгаж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар³-т ирүүлэх

³ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019

650261222

биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга Б.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Т.БАЙГАЛМАА
В.ЦОГЖАРГАЛ

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 410/10370462

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө" сэдэвт аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж баталсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-д "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг", 6 дугаар зүйлийн 6.10-д "Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна" 6.10.1-д "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах арга хэмжээ авч,

650261216

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн засаг дарга Б.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Т.БАЙГАЛМАА
АУДИТОР		В.ЦОГЖАРГАЛ

6517143980
АЮА0052 9001034